



Тусгай дугаар

## ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ҮЙЛДВЭР, БӨРТЭ ТӨААТҮГ-ЫН 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!

### МЭНДЧИЛТЭЭ

Ардын хувьсгал ялж Монгол орон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа сэргээн мандуулахтай зэрэгцэн улс орноо хөгжил дэвшилд түүчээлэх шинэ цагийн олон салбар үүсэн байгуулагдах нөхцөл боломж бүрдсэн билээ. Монгол Улсад хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжих тулгын чулууг тавьсан Цэргийн дүрэмт хувцасны анхны үйлдвэр үүсэн байгуулагдаж, түмэнд нэрээ, төр улсдаа алдраа дуурсгаж эхэлсний түүхт 100 жилийн ой тохиож байгаад баяртай байна. Дэлхийн мянганы суут хүн Эзэн богд Чингис хааны цэцэн бэлэгт хатан Бөртэ-Ужингийн эрхэм алдраар овоглож, бахдам амжилт бүтээлээр Монгол орон даяар нэр нь түгж, алдаршсан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт С.Янжмаагийн нэрэмжит Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨААТҮГ-ын түүхэн замнал нь Монгол Улсын Батлан хамгаалах салбар, түүний хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой. Эх орноо батлан хамгаалах цэрэг эрстэй болж, тэднийг дүрэмт хувцсаар хангах шаардлага тулгарсан цаг үеэс тус үйлдвэрийн үндэс суурь тавигдаж гар үйлдвэрийн жижиг артелиас цэргийн оёдлын цех, улмаар орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон хөгжиж бэхэжсэн 100 жилийн түүх бол олон зуун ажилтан, алба хаагчдын уйгагүй хөдөлмөр, их бүтээлээр амилан буухиалсан, хөдөлмөр буцалсан он жилүүдийн түүх юм.

1921 онд Ардын журамт цэрэг харийн түрэмгийлэгчдийг эх нутгаасаа хөөн зайлуулж, улс гэрээ төвшин амгалан болгох ялалтын уухай Шивээ Хиагтаас цуурайтаж байсан тэр цаг дор их жанжин Д.Сүхбаатарын санаачилга, хүсэлтээр журамт цэргүүдийн гэргий, үйлчин бүсгүйчүүд цэргүүдийн хувцас хунарыг оёж эхэлснээр энэ үйлдвэрийн үндэс суурь тавигдсан билээ. Тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагаар Цэргийн гар үйлдвэр байгуулагдсан нь манай улсын хөнгөн аж үйлдвэрийн түүхэн дэх анхдагч үйлдвэр болсон төдийгүй, ажилчин анги үүсэх үндэс суурийг тавьснаараа Батлан хамгаалах салбарын төдийгүй, улс орны түүхэнд онцлон тэмдэглэгдсэн үйл явдал болсон. Цэргийн дүрэмт хувцасны үйлдвэр Монгол Улсын төрийн цэргийн байгууллагуудыг дүрэмт хувцас хэрэглэлээр

хангах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн. Тус үйлдвэрийн үйлчин бүсгүйчүүдийн уран гар, ухаан билгээр урласан дүрэмт хувцсыг 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон дарга, цэргүүд өмсөж, эх орноо өмгөөлөн хамгаалсан бөгөөд их ялалтад оруулсан үйлчин бүсгүйчүүдийн хувь нэмрээр бахархах учиртай.

Энх цагийн бүтээн байгуулалтын жилүүдэд тус үйлдвэрээс хөдөлмөрийн гарамгай амжилт гаргасан олон арван ажилтан ажилчид төр, засгийн өндөр цол хэргэм, одон медаль хүртэж ирсэн нь үйлдвэрийн хөдөлмөрч уламжлал, бүтээлч, ажилсаг хамт олны зүтгэл чармайлыг илтгэн харуулдаг юм.

Тус үйлдвэр улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн хүнд цаг үеийг амжилттай даван туулж, хөгжлийн эрч, далайцаа сааруулалгүй ажиллан, улс орондоо нэр хүндтэй шилдэг тэргүүний байгууллага, хамт олон болсон амжилтаар түүхт ойгоо угтаж байгааг Батлан хамгаалах салбарын удирдлага, бие бүрэлдэхүүн өндөр үнэлж байгааг энэ дашрамд тэмдэглэхэд таатай байна. Дүрэмт хувцасны уран үйлчид-"Бөртэ"-чүүдийн ойн баяр нь тус үйлдвэрийн хамт олны төдийгүй, тус үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг бүх хүмүүс, хамтран ажилладаг байгууллагуудын хамтын баяр юм. Үйлэнд уран, сэтгэл нь цайлган бүсгүйчүүдийн урласан хувцсыг өмсөж, төрийн хариуцлагатай чухал албыг залгуулж яваадаа бид сэтгэл хангалуун байдаг юм.

БХЯ-ны харьяа С.Янжмаагийн нэрэмжит Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨААТҮГ-ын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан тус үйлдвэрийн түүхийг бичилцсэн эрхэм хүндэт ахмадууд, тэдний хөдөлмөрч уламжлалыг өнөө цагт буухиалан яваа ажилтан, албан хаагчид Та бүхэнд ойн баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил хөдөлмөрийн улам их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Та бүхний үйл уран, бүтээл арвин байх болтугай.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

## БӨРТЭ ТӨААТҮГ-ЫН ХАМТ ОЛОН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙГОО ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭЖ БАЙНА

Батлан хамгаалах яамны харьяа Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт С.Янжмаагийн нэрэмжит Цэргийн дүрэмт хувцасны үйлдвэр "Бөртэ" ТӨААТҮГ-ын 100 жилийн ойд зориулсан ёслол хүндэтгэлийн арга хэмжээ өнөөдөр ЦДБЭЧ-ын концертын танхимд болж байна.

100 жилийн ойн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, Батлан хамгаалахын Дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны ХШҮДАГ-

ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, ЗХЖШ-ын Ар талын газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр, Зэвсэгт хүчний Барилга инженерийн цэргийн удирдах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, Бөртэ ТӨААТҮГ-ын Ерөнхий захирал, хурандаа Д.Энхтайван, Бөртэ ТӨААТҮГ-ын ахмад ажилтан, Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Л.Нямаа тэргүүтэй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, Бөртэ ТӨААТҮГ-ын үе үеийн удирдлага, ахмад ажилтнууд, одоо ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцлоо.



## Түүхэн үйл явдлын товчоон

➤ Монгол ардын журамт цэрэг Хиагтыг чөлөөлсний дараа буюу 1921 оны 3 дугаар сарын 24-нд хуралдсан МАХН-ын Анхдугаар хурлаас Д.Сүхбаатарын санаачилгаар журамт цэргийн хувцас, хэрэглэлийг сэлбэн засах, ардын журамт цэргийн анхны соёмбот туг оёх ажилд цэргийн ар гэрийн хүмүүсийг татан оролцуулж, оёдлын бүлгэм байгуулж, үйлдвэрийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

➤ Ардын хувьсгалыг бататган бэхжүүлэх үүднээс цэргүүдийн тоог нэмэгдүүлэн байнгын армитай болох шаардлагатай болсон учир дарга, цэрэг нарыг нэгэн зэрэг нормын хувцас, ор дэрний хэрэглэээр хангах зорилгоор 1922 оны 1 дүгээр сарын 7-нд "Бэлтгэн үйлдэх тасал" нэртэйгээр цэргийн гар үйлдвэрийг албан ёсоор байгуулан даргаар нь Мөнхийн Дандий томилогдон ажилласнаар тус үйлдвэрийн буюу манай Улсын Хөнгөн Үйлдвэрийн үндэс суурь анх тавигдаж, анхны ажилчин анги үүсэн бий болсон нь түүхийн алтан хуудаснаа тэмдэглэгджээ.

➤ 1922 оны 1 дүгээр сарын 7-нд үйлдвэрийг байгуулах үед үйлчний хайч, зүү, тэвнээс өөр ямар нэгэн багаж хэрэгсэл байхгүй, дан ганц гар оёдлоор хувцас хэрэглэл хийдэг байсан учир "Гар үйлдвэр" хэмээн нэрлэжээ.

➤ 1923 оны 5 дугаар сарын 18-нд Монголд үйл ажиллагаагаа явуулж байсан Оросын оёдлын үйлдвэрийг бүх хөрөнгийн хамт цэргийн оёдлын үйлдвэрт үнэ төлбөргүй шилжүүлэн өгч материаллаг баазыг өргөтгөжээ.

➤ 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны хүнд бэрх жилүүдэд цэргийн оёдлын үйлдвэр, цэрэг армийнхаа найдвартай ар талын нэгэн хэсэг байж, өөрийн армийг хувцас хэрэгслээр бүрэн хангаж, жилд 1 сая төгрөгийн нэмүү бүтээгдэхүүн үйлдвэрлэж,

Зөвлөлтийн улаан армид нийлүүлж байсан юм.

➤ 1947 оны 3 дугаар сарын 23-нд үйлдвэрийн 25 жилийн ойгоор Цэргийн оёдлын үйлдвэрийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнан С.Янжмаагийн нэрэмжит болгосон нь хамт олны сэтгэл оюуныг ирлэн, хурцалсан сайхан үйл явдал болсон юм.

➤ Тус үйлдвэр нь 1962 оны 5 дугаар сарын 25-нд одоогийн үйлдвэрийн шинэ барилгад шилжин орж, 1970 оны 6 дугаар сарын 19-нд үйлдвэрийн дэргэд Туршилт, шинжилгээний лаборатори байгуулж, бүх төрлийн хувцасны улсын стандарт тогтоосон байна.

➤ 1970 оны 10 дугаар сарын 27-ноос Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулж эхлэх үеэр Цэргийн оёдлын үйлдвэр нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлж, 1000 давсан ажилчинтайгаар ээлжийн системээр уртасгасан цагаар БХЯ, НАХЯ-ны олон мянган цэрэг цагдаа, офицер дарга нарын дүрэмт хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэн бүтээж, ханган нийлүүлж чадсан билээ.

➤ 1970 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс асар майхан, ор дэрний хэрэглэл зэрэг зүйлсийг үйлдвэрлэх Цэргийн оёдлын 2 дугаар үйлдвэрийг Налайхад байгуулан ажиллуулсан юм.

➤ Улс орон зах зээлийн тогтолцоонд шилжиж, Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагын тухай хууль мөрдөх болсонтой холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 1991 оны 2 дугаар сарын 20-нд 910 тоот тушаалаар тус үйлдвэрийг Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" үйлдвэр болгон өөрчлөн зохион байгуулсан билээ.

➤ 1990 оноос эхлэн улс орны улс төр, нийгэм эдийн засгийн харилцаанд гүнзгий

өөрчлөлт орсон зах зээлийн шилжилтийн хүнд цаг үеүүдэд улсын томоохон үйлдвэрүүд хаалгаа барьж байсан бол Цэргийн оёдлын үйлдвэр нь энэ байдлыг даван туулж, улс армидаа нэр хүндтэй тэргүүний байгууллага болж чадсан юм.

➤ 1991 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс генерал, офицеруудын шинель, хээрийн китель өмд, өдөр тутмын китель, пелник, дотуур цамц, мөрдэс, малгай зэрэг бүх төрлийн хувцасны загварыг өөрчлөн Хүндэт харуул, Цэргийн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн хөгжимчдийн хувцсыг үндэсний хэв загвартай болгон, цолны болон таних тэмдгийг үндэсний өлзий хээгээр сольж, нисгэгчид, цагдаагийн байгууллагын ажилтнуудын хувцсыг өөрчлөн шинэчлэн үйлдвэрлэх болсон билээ.

➤ БХЯ-ны харьяа Дүрэмт хувцасны "Бөртэ" оёдлын үйлдвэрийн одоогийн хамт олон галыг манаж голомтыг сахиж, намтар түүхийг нь нэмэн баяжуулсаар байгаа төдийгүй одоо тус үйлдвэр нь жилд 1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай 974 кв талбай бүхий үйлдвэрийн зориулалттай байранд 200 гаруй ажиллагсадтай, 350 гаруй ахмад настантай, захирлын ажлын албанаас гадна санхүү, үйлдвэрлэл, аж ахуй засвар үйлчилгээ гэсэн албадтай, эсгүүр, захиалгат оёдол, бөөнөөр үйлдвэрлэх тасагтайгаар Зэвсэгт хүчний болон төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүний хувцас хэрэглэлийн тендер шалгаруулалтад оролцон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан загвар, стандартаар үйлдвэрлэж байгаагаас гадна энгийн байгууллагуудаас захиалгаар ажлын болон тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг оёж нийлүүлж байна.

## ОЙГ УТГСАН БҮТЭЭЛЧ АЖЛУУД

1. Үйлдвэрийн гадна фасадын засвар, шинэчлэлт хийв
2. Үйлдвэрийн гадна талбайн зулэг цэцэрлэгжүүлэлт хийв.
3. Үйлдвэрийн барилга доторх цэвэр бохир усны шугам сүлжээг сольж шинэчлэх засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.
4. Бараа материал хадгалах 140 м2 агуулах шинээр барьж, автогражийн хаалгыг шинэчилсэн
5. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 1000 мод тарьсан
6. ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоог үйлдвэрлэлд нэвтрүүлсэн
7. Монгол Улсын Оюуны Өмчийн зохиогчийн эрхийн гэрчилгээг "Цэргийн албан хаагчийн дүрэмт хувцас" бүтээлээр авсан.
8. CLO-3D Программыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Энэ нь загвар зохион бүтээгчийн ажилд цаг хугацаа мөн гар ажиллагааг хөнгөвчилсөн ажил болж байна.
9. Урлагийн үзлэг зохион байгуулсан
10. Монгол цэргийн музейтэй хамтарсан Цэргийн дүрэмт хувцасны үзэсгэлэн зохион байгуулав
11. ЦДБЭЧ-тай хамтран баярын концерт зохион байгуулав
12. Дуулга студитэй хамтран БӨРТЭ ТӨААТҮГ-ын баримтат кино, шторк хийсэн
13. Бөртэ амралтын газар ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа
14. 100 жилийн ойд зориулсан "Бөртэ" брэндийг бий болгохоор ажиллаж байна.

## МИНИЙ АМЬДРАЛЫН 42 ЖИЛ ТУС БАЙГУУЛЛАГАТАЙ САЛШГҮЙ ХОЛБООТОЙ



Ахмад ажилчин Д.ЛХАГВАЖАВ

1977 онд 8 дугаар анги төгсөөд 16 настайдаа энэхүү үйлдвэрийн алтан босгоор алхан орж байлаа. Түүнээс хойш буюу 42 жил уг байгууллагад ажиллахаа Малгайн бригадад оёдолчин, Захиалга оёдлын тасагт оёдолчин, мастер чанар шалгагч гэх мэт албан тушаалыг хашсан. Байлдагчаас генерал хүртэлх цэргийн дүрэмт хувцсыг оёж сурахад үе үеийн мастерууд, багш нар хамт олон маань үргэлж зааж зөвлөж, тусалж ирсэн. Миний тувьд хүнийг хувцаслана гэдэг бол бурхнаас өгсөн бэлэгтэй зүйрлэхүйц чухал. Миний оёсон, миний хөдөлмөр шингэсэн тэрхүү хувцсыг өмсөөд өөртөө итгэлээр дүүрэн алхаж буй цэргийн нөхдөө харах бүр ч сайхан. Нэгэн цагт мөр зэрэгцэн зүтгэж явсан алба хаагчид, найз нөхөдтэйгөө эргэн уулзах нь буцаад залуу насандаа очсон мэт сэтгэгдлийг төрүүлж байна. Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонт С.Янжмаагийн нэрэмжит Цэргийн дүрэмт хувцасны үйлдвэр "Бөртэ" ТӨААТҮГ-ын үе үеийн удирдлага, ахмад ажилтнууд, одоо ажиллаж байгаа бие бүрэлдэхүүндээ түүхт 100 жилийн ойн баярыг хүргэж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

## ГЕНЕРАЛ ЦОЛТНЫ ДҮРЭМТ ХУВЦСЫГ УРЛАНА ГЭДЭГ ХҮН БҮРД ОЛДОХ БОЛОМЖ БИШ



Ахмад ажилчин М.ЧИМЭДТАЯА

Анх 16 настайдаа Дундговийн оёдлын үйлдвэрт оёдолчноор ажиллаж байгаад 22 настайдаа энэхүү цэргийн дүрэмт хувцсыг урлах эрхэм үүргийг гүйцэтгэгчдийн эгнээнд элсэж байлаа. Оёдолчин мастер, мастер багш, үйлдвэрийн хэлтсийн дарга гэх мэт албан тушаалыг хашиж байгаад тэтгэвэртээ гарсан. Байлдагчаас генерал хүртэлх цэргийн алба хаагчдын дүрэмт хувцсыг бэлтгэнэ гэдэг бид бүхний бахархал. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар генерал цол хүртэж буй хүнийг хувцаслаад гаргана гэдэг оёдолчин хүн бүрд олдох боломж биш. Олон сайхан дурсамжийг бүтээж, он цагийг хамт элээсэн үе үеийн удирдлага, ахмад ажилтнууд, одоо ажиллаж байгаа бие бүрэлдэхүүндээ түүхт 100 жилийн ойн баярыг хүргэе.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)